



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

### Дугаар №27



2018 оны 8-р сарын 06-10-ны хооронд

#### НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **1133** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 102(9.0%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1008(88.9%) хачигт халдвар, 11(1.0%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 7(0.6%) боом, 4(0.4%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

##### 1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1008** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18%-иар бага байна. Эпидемиологийн 31-р долоо хоногтой харьцуулахад 12 сэжигтэй тохиолдлоор их байна.



8 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар хачигт риккетсиозын 747 сэжигтэй тохиолдлын 181(24.2%), хачигт энцефалитын 174 сэжигтэй тохиолдлын 32(18.4%), хачигт боррелиозын 87 сэжигтэй тохиолдлын 23(26.4%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 113 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

##### 1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **102** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11%-иар бага байна. Эпидемиологийн 31-р долоо хоногтой харьцуулахад 2 эрсдэлд өртсөн тохиолдлоор их байна.



### 1.3 Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Нийслэлийн Хан-Уул дүүрэг, Ховд аймгийн Булган суманд тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдэж, тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

### 1.3 Боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Завхан аймгийн ЗӨСТ-өөс ирүүлсэн мэдээгээр боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол мэдээлэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

### 1.4 Мэрэгч амьтны сэжигтэй дуудлага:

8 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийслэлийн СБД, БГД-ээс ирүүлсэн амьтны 3 удаагийн дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторит шинжилгээ хийгдэж байна. Он гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 40 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

## ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

### Монгол улсад:

#### Шүлхий өвчин:

Өвөрхангай аймгийн Баянгол сумын Цагаанбулан багийн “Эрээн тээг” гэдэг газар 8 дугаар сарын 02-ны өдөр малчин айлын 2 өрхийн 35 хонинд шүлхий өвчний шинж тэмдэг илэрч, 8 дугаар сарын 03-ны өдөр дээж авч шинжлүүлэхэд, 04-ны өдрийн УМЭАЦТЛ-ийн шинжилгээний дүнгээр шүлхий өвчин болох нь тогтоогдсон. Тус суманд 8 дугаар сарын 04-нд хорио цээрийн дэглэм тогтоож, голомтод бүсэд байгаа 1531 толгой малыг вакцинжуулж, 35 малыг тусгаарласан байна. Өвөрхангай аймгийн ЗӨСТ мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллаж байна

Эх сурвалж: ОБЕГ

### Тарваган тахлын хамтарсан тандалт судалгаа:

7 дугаар сарын 01-нээс, 8 дугаар сарын 01-ний хүртлэх хугацаанд Монгол-ОХУ-ын хамтарсан судалгааны баг Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цагааннуур, Ногооннуур сумдын нутагт тарваган тахал өвчний байгалийн голомтын тандалт судалгааг амжилттай хийсэн.

Судалгааны дүнгээр дээрхи сумдын нутаг дах тарваган тахлын байгалийн голомт идэвхитэй байгааг тогтоосон байна.




Эх сурвалж: ЗӨСҮТ

### Олон улсад:

#### Бог малын мялзан төст өвчин: Бурунди улс

Бурунди улсын Канянка хотын Муханга мужид малын мялзан өвчин бүртгэгдэж, 44 хонь, ямаа өртсөнөөс, 22 хонь, ямаа өвчилж, 20 хонь, ямааг устгасан. Муханга мужид хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.




#### Шувууны томуу өвчин: Малайз улс

Малайз улсын Сабах хотын Туаран мужид шувууны томуугийн H5N1 вирүст халдварын дэгдэлт шувууны аж ахуйд бүртгэгдэж, 28000 шувуу өртсөнөөс, 3000 шувуу өвчилж үхэн, 25000 шувууг устгасан. Тус голомтод хязгаарлалтын дэглэм тогтоожээ.




#### Баруун нилийн халуурал өвчин: Грек улс

Грек улсын Тэйсслоники хотын Кентрики Македони мужид Баруун нилийн халуурал бүртгэгдэж 8 адуу өртсөнөөс, 1 адуу өвчилсөн байна.



## Шувууны томуу өвчин: ОХУ

ОХУ-ын Нижегородская мужид өндөр хоруу чанартай шувууны томуу өвчний дэгдэлт бүртгэгдэж, 90 шувуу өртсөнөөс, 2 шувуу өвчилж үхэн, 88 шувууг устган Нижегородская мужид хязгаарлалтын дэглэм тогтоожээ.



**Эх сурвалж:** Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага

**Жич:** Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Баян-Өлгийн, Хэнтий, Хөвсгөл, Өмнөговь, Төв, Завхан, Дундговь аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн.

Салбар төвүүд ШУН-ийн [eop@nczd.gov.mn](mailto:eop@nczd.gov.mn) мэдээгээ ирүүлж байна уу?